

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	2
1.1.Төслийн нэр : “Эмийн үйлдвэр” төсөл	2
1.2.Төсөл хэрэгжүүлэгч :	2
1.3.Төслийн байршил :	2
1.4. Төслийн танилцуулга.....	3
1.5.Төслийн хүчин чадал	4
1.6. Лабораториуд	4
1.7. Ашиглах химийн бодисын жагсаалт	8
1.8. Төслийн дэд бүтэц.....	15
2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	38

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн булангийн солбицол	2
Хүснэгт 2. Импортлон оруулж ирэх бодисын жагсаалт.....	8
Хүснэгт 3. Төслийн ажилчдын унд ахуйн усны тооцоо	15
Хүснэгт 4. Ногоон байгууламжийн услалт	15
Хүснэгт 5. Эмийн үйлдвэрийн усны хэрэглээ.....	16
Хүснэгт 6. БОМТөлөвлөгөөний зардлын дүн	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Байршлын зураг	2
Зураг 2. Монхимо үйлдвэрийн цогцолборын план зураг	4
Зураг 3. Химийн шинжилгээний чанарын хяналтын лаборатори	5
Зураг 4. Микробиологийн чанарын хяналтын лаборатори	5
Зураг 5. Бүтээгдэхүүн хутгалтын тогоо.....	6
Зураг 6. Бүтээгдэхүүн пакетлагч машин	6
Зураг 7. Жин	6
Зураг 8. Эхлэл материал болон туслах материалын агуулах	7

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1.Төслийн нэр : “Эмийн үйлдвэр” төсөл

1.2.Төсөл хэрэгжүүлэгч :

“Монхимо” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011111079, регистрийн дугаар 2559994,
Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 000026234

Багануур дүүргийн засаг даргын захирамж 2013 оны 12 сарын 16-ний өдрийн 481/2 тоот, Багануур дүүргийн 3-р хорооны Үйлдвэрийн хэсэгт байрлах 1203010121 нэгж талбарын дугаартай 2703 м² газартай. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар 000097804


Захирал: М.Ариунаа утас: 99118936 email хаяг: monchemo1998@yahoo.com

1.3.Төслийн байршил :

Нийслэлийн Багануур дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт 2703 м² талбайд хэрэгжинэ. “Монхимо” ХХК-ийн газар нь дүүргийн үйлдвэрийн бүсэд үйлдвэрийн зориулалттай газарт байрлаж байна.

Хүснэгт 1. Талбайн булангийн солбицол

Д/д	Градус	Мин	Сек	Градус	Мин	Сек
1	108	22	2.43	47	46	1.78
2	108	22	3.02	47	46	2.46
3	108	22	3.46	47	46	2.78
4	108	22	3.87	47	46	2.61
5	108	22	4.0	47	46	2.56
6	108	22	4.02	47	46	2.64
7	108	22	4.63	47	46	2.48
8	108	22	4.55	47	46	2.36
9	108	22	5.46	47	46	2.03
10	108	22	6.23	47	46	1.73
11	108	22	5.49	47	46	0.87
12	108	22	5.23	47	46	0.76
13	108	22	4.95	47	46	0.71
14	108	22	3.09	47	46	1.38
15	108	22	3.19	47	46	1.5



Зураг 1. Байршлын зураг

Үйлдвэрийн байршил нь Багануур дүүргийн 3-р хорооны үйлдвэрийн бүсэд хэрэгжинэ. Төслийн талбай нь 0.2га талбайг эзлэн оршдог бөгөөд орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 1000 м-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангаж байна.

Тус стандартын 5-р хавсралт буюу эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 50 м-т хамаарах аж ахуй нэгж, химийн бүтээгдэхүүний үйлдвэр дэд ангилал дотор 1.8-т эмийн үйлдвэрийн төрөлд тухайн төсөл хамаарч байна.

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангаж байна.

Тус стандартын 4-р хавсралт буюу агуулахын байршилд тавих шаардлага дэд ангилал дотор 4.2-т зэргэлдээх барилга, байгууламжаас дор дурдсанаас бага зайд байрлаж болохгүй гэсэн ангилалын 4.2.2-т төрөлд тухайн төсөл хамаарч байна. 5-р хавсралт агуулахын барилгад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

1.4. Төслийн танилцуулга

ШУУ-ийн Монхимо ХХК 1998 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлснээс хойш эдүгээ 23 дахь жилдээ *Анагаах ухаан – ариутгалын бодис, бэлдмэлийн үйлдвэрлэл худалдаа, Байгаль орчин, Хөдөө Аж Ахуйн салбарт* үйл ажиллагаа явуулж байна.

Монхимо эмийн үйлдвэр нь дэлхийн хөгжилтэй орнуудад өргөн хэрэглэгдэж буй гадаргуугийн идэвхт 4 төрлийн бодис агуулсан дараах бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг. Үүнд:

- Тамедин 18 цуврал
- Химодин
- Ариун
- Санитол.

2007 оноос Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Эрдэм шинжилгээ туршилтын төв (ЭШТТөв)
- Ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмийн үйлдвэр
- Биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэр
- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх төв
- Ясны сийрэгжилт оношилгооны төв

Хөгжүүлэлтийн төлөв байдал:




Ариутгал халдваргүйтгэлийн бодис, эмийн үйлдвэрийг МУИС-ийн хөгжлийн сангийн дэмжлэгээр 1998 онд байгуулсан бөгөөд Эрүүл мэндийн яамнаас олгодог тусгай зөвшөөрлөөр “Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS5524:2014” үндэсний стандартыг мөрдөн ажиллаж байна.

Манай эмийн үйлдвэр 1998 онд үйл ажиллагаа эхэлсэн цагаас халдвар хамгааллын чиглэлээр хүн ба мал эмнэлэг, нийтлэг үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт болон хувийн хэвшлийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна.

Монхимо эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн нь олон улсын нэгдүгээр зэрэглэлийн антисептикт хамаарагддаг, иодофорын төрлийн “Тамедин” “Химодин” нэрийн 2 цуврал бүтээгдэхүүн. Дөрөвдөгч аммонийн нэгдлийн “Ариун” халдваргүйтгэлийн уусмал, Этилийн спирт 70% агууламжтай “Санитол” гар халдваргүйжүүлэгч бэлдмэлийг үйлдвэрлэх технологи, стандартыг боловсруулж, үйлдвэрлэлийн фармакофей болон үндэсний стандартаар батлуулан, зах зээлд гарган ажиллаж байна. 2007 онд Багануур дүүрэгт өөрийн эзэмшлийн байранд шилжин ажиллаж байгаа бөгөөд өдөрт 1-1,5 тн ариутгал халдваргүйтгэлийн бодис бэлдмэл үйлдвэрлэх хүчин чадалтай.

Цаашид GMP, GLP, ISO стандартын шаардлагад нийцсэн үйлдвэрийн шинэчлэлийн бүтээн байгуулалтыг 2019-2025 онд гүйцэтгэж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



Зураг 2. Монхимо үйлдвэрийн цогцолборын план зураг

1.5.Төслийн хүчин чадал

- Монхимо эмийн үйлдвэр нь өдөрт 5000-6500 флакон буюу 119.6тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Монхимо эмийн үйлдвэр нь 32 ажилтантай бөгөөд мэргэжлийн эм зүйч, химич, микробиологи, лаборант, нярав, туслах ажилтан гэсэн ажлын байруудад ажиллаж байна.

1.6. Лабораториуд

Химийн шинжилгээний чанарын хяналтын лаборатори

- Химийн лаборатори нь бүтээгдэхүүний физик, химийн үзүүлэлтийг ҮФӨ болон МУ-ын стандартын дагуу хийж гүйцэтгэдэг.


- Титерлэгч, электрон рН метр, электрон жин, хэмжээст цилиндр, колбо, соронзон хутгагч, автомат пипетка, хатаах шүүгээ зэрэг багаж, төхөөрөмжтэй.
- Грийн хими, Цэцүүх трейд, Реактив зэрэг компаниудаас чанар стандартын шаардлага хангасан урвалж бодисыг авч шинжилгээндээ хэрэглэж байна.



Зураг 3. Химийн шинжилгээний чанарын хяналтын лаборатори

Микробиологийн чанарын хяналтын лаборатори

- Микробиологийн лаборатори нь бүтээгдэхүүний болон, орчны эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийдэг.
- Ламинар бокс, микроскоп, термостат, колони тоологч, автоклав зэрэг багаж, төхөөрөмжтэй.
- Гялс био, Монбиофарм, Цэцүүх зэрэг компаниудаас чанар стандартын шаардлага хангасан тэжээлт орчингуудыг авч шинжилгээндээ хэрэглэж байна.



Зураг 4. Микробиологийн чанарын хяналтын лаборатори



Зураг 5. Бүтээгдэхүүн хутгалтын тогоо



Зураг 6. Бүтээгдэхүүн пакетлагч машин



Зураг 7. Жин



Зураг 8. Эхлэл материал болон туслах материалын агуулах

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1.7. Ашиглах химийн бодисын жагсаалт

Хүснэгт 2. Импортлон оруулж ирэх бодисын жагсаалт

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
1	(3-хлор-2-гидроксипропил)	(3-chloro-2-hydroxypropyl)	3327-22-8	C6H15Cl2NO	200
2	1,2-гександиол	1,2 Hexanediol	6920-22-5, 84994-66-1	C6H14O2	10
3	2,4-Dichlorophenoxyacetic acid	2,4-Dichlorophenoxyacetic acid	94-75-7	Cl2C6H3OCH2CO2H	200
4	Ацетил карнитин	Acetyl-L-Carnitine	14992-62-2	C9H17NO4	10
5	Acorus calamus үндэсний ханд	Acorus calamus root ext	84775-39-3	Not available.	10
6	Алфа-Липойк хүчил	Alfa-lipoic acid	1077-28-7	C8H14O2S2	20
7	Аллицин	Allicin	539-86-6	C6H10OS2	20
8	Алое барбаденсын нунтаг	Aloe barbadensis powder	85507-69	C16H13NO3	40
9	Молебдены хүчлийн аммон	Ammonium molybdenic acid	CAS 12054-85-2	(NH4)6Mo7O24 4H2O	8,000
10	Азот хүчлийн аммони	Ammonium nitrate	6484-52-2	NH4NO3	100,000
11		Avocado refined butter		Not available.	100
12	Банаба ханд	Banaba extract	4547-24-4	Not available.	30
13	Зөгийн воск (лав)	Bees wax	8012-89-3	C15H31CO2C30H61	300
14	Бензойны хүчлийн натри	Benzoic acid sodium salt	532-32-1	C6H5COONa	1,000
15	Бензотриазол	Benzotriazole	95-14-7	C6H5N3	60
16	Бетаин	Betain	107-43-7	C5H11NO2	60
17	бетайн гидрохлорид	Betaine hydrochliride	107-43-7	C5H11NO2	100
18	Бетайн гидрохлорид	Betaine hydrochloride	107-43-7	C5H11NO2	100
19	Биттер Милон	Bitter milon	6211-32-1	Not available.	20
20	Борын цитрат	Boron citrate	7440-42-8	C18H15BO21	20
21	Боевеллиа Серрата	Boswellia Serrata	67416-61-9	Herbal extract C32H48O5	100
22	брокколи ханд	Broccoli ext	223749-36-8	C6H11NOS2	200
23	Бромелайн	Bromelain	37189-34-7	Not available.	200
24	Гурвалжин будааны ханд	Buckwheat extract	8995809-8	Not available.	80
25	бутилен гликол	Butylene glycol	107-88-0 6290-03-5	C4H10O2	80
26	Кальцийн ацетат	Calcium acetate	62-54-4	Ca(C2H3O)2	20,000
27	Хлорт кальци	Calcium chloride	10043-52-4	CaCl2	20,000
28		Calcium chloride food grade	10035-04-8		200
29	КАНДЕЛИЛА сера	Candelilla Cera	8006-44-8	Not available.	60
30	Капсайцин	Capsaicin	404-86-4	C18H27NO3	20
31	Карбопол	Carbopol	2594322	C3H3NaO2	800
32	Карбопол - 940, (941)	Carbopol - 940, (941)	9003-01-4	C3H3NaO2	800
33	Казейн	Casein	9000-71-9	C81H125N22O39P	1,000
34	Боловсруулсан катионт цардуул	Cationic starch	56780-58-6	C6H12O5)n	100,000

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
35	Катионик сурфактант С-980	Cationic surfactant C-980p			50,000
36	Катионик сурфактант С-991	Cationic surfactant C-991 PL			40,000
37	Седар холтосны ханд	Cedar bark extract		Not available.	70
38	Цетеарилын спирт	Cetearyl Alcohol	36653-82-4	C16H34O	1,000
39	цетил алкоголь	Cetyl alcohol	36653-82-4	C16H34O	600
40	Цетилмеристолате	Cetylmyristoleate	64660-84-0	C30H58O2	60
41	цетилпиридиinium хлорид	Cetylpyridinium chloride	123-03-5	C21H38ClN	40,000
42	Цетилстеарил алкоголь	Cetylstearyl alcohol	67762-27-0	CH ₃ (CH ₂) _n OH; n=variable, typically 15-17	800
43	Хлор гексидин	Chlorohexidine	55-56-1	C ₂₂ H ₃₀ Cl ₂ N ₁₀ •2C ₆ H ₁₂ O ₇	2,000
44	Холин хлорид	Choline chloride	67-48-1	C ₅ H ₁₄ ClNO	200
45	Хромын нитрат	Chromium nitrate	13548-38-4	Cr(NO ₃) ₃	1
46		Chymosin	9001-98-3		100
47		Chy-max M powder			60
48	Циннамон ханд	Cinnamon extract	621-82-9	Not available.	200
49	Лимонны хүчил	Citric acid monohydrate ≥ 99.5%	5949-29-1	C ₆ H ₈ O ₇ *H ₂ O	60
50	сульфат кобальт	Cobalt sulfate	10026-24-1	CoSO ₄ 7H ₂ O	6,000
51	Кокамид ДЭА	Cocamide DEA	68603-42-9	CH ₃ (CH ₂) _n C(=O)N(C ₂ H ₅ OH) ₂	1,000
52	Кокамидопропилбетаин	Cocamidopropyl Betaine	61789-40-0	C ₁₉ H ₃₈ N ₂ O ₃	100,000
53	Кокоамид ДЕА	Cocoamide diethanolamine	68603-42-9	C ₄ H ₁₁ NO ₂	100
54	Кокоглюкозид	Coco-Glucoside	141464-42-8	C ₁₆ H ₃₂ O ₆	10
55	Кокосын диетаноламид	Coconut diethanolamide	68603-42-9	C ₁₃ H ₁₃ C ₁₈ NO ₄	1,000
56	коэнзим Кю-10	coenzyme Q10	303-98-0	C ₅₉ H ₉₀ O ₄	4
57	Ко-энзим Q-10	Coenzyme Q-10	303-98-0	C ₅₉ H ₉₀ O ₄	20
58	Коллаган	Collagen hydrolysate	92113-31-0		400
59	Коллаган	Collagen hydrolysate	92113-31-0		400
60	Цууны хүчлийн зэс	Copper Acetate monohydrate	6046-93-1	CuC ₂ H ₃ O H ₂ O	200
61	сульфат зэс	Copper sulfate	7758-99-8	CuSO ₄ 5H ₂ O	10,000
62	Кремофор	Cremophor	61791-12-6		200
63	Хромын аспартат	Chromium aspartate		C ₁₂ H ₁₅ Cr ₂ N ₃ O ₁₂	1
64	Хромын пиколинат	Chromium Picolinate	14639-25-9	Cr(C ₆ H ₄ NO ₂) ₃	7
65	өргөст хэмхийн ханд	Cucumber ext	89998-01-6		40
66	Нимбэгний хүчлийн зэс	Cupric citrate	10402-15-0	C ₆ H ₈ Cu ₂ O ₇ +4	60
67	Куркумин	Curcumin			50
68	Куркумин ханд	Curcumin(turmeric root)			50
69	Куркумин ханд	Curcumin(turmeric root)	458-37-7	C ₂₁ H ₂₀ O ₆	50

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
70	Дарсны хүчил	D,L-tartaric acid	133-37-9	HOOC(CHOH)2COO H	200
71	Децил глюкозид	Decyl Glucoside	58846-77-8	C16H32O6	20
72	Глюкоз	D-Glucose	50-99-7	C6H12O6	100
73	Динатрийнлаурелсул фосукцинат	Disodium laureth sulfosuccinate	39354-45-5	C32H58Na2O14S2	1,000
74	Метионине	DL-Methionine	59-51-8	C5H11NO2S	40
75	Витамин Е	DL-Tocopherol ≥ 96%	10191-41-0	C29H50O2	100
76	Рибоз	D-ribose	50-69-1	C5H10O5	20
77	Д-сорбитол	D-sorbitol	9028-22-2		200
78	Эластин	Elastin	9007-58-3	C27H48N6O6	20
79	этанол	Ethanol	64-17-5	C2H5OH	200
80	Этилийн спирт (дээд зэргийн цэвэршилттэй)	Ethyl alcohol high purity	64-17-5	C2H5OH	100
81	Фенугрийк-ийн үрийн ханд	Fenugreek Seed extract	Not available.	Not available.	800
82	Фермент	Fermented soy bean powder		Not available.	2,000
83	FLOBEADS DB45	FLOBEADS DB45		Not available.	10,000
84	Флокуат 45	Floquat TS 45		Not available.	10,000
85		Foaming Bath Butter Base		Not available.	1,000
86	Фруктоз	Fructose			90
87	Гарциния Камбожи	Garcinia cambogia	90045-23-1	Not available.	60
88	Желатин	Gelatine			1,000
89	Глютамини хүчил	Glutaminic acid	56-86-0	HOCC ₂ H ₂ CH(NH ₂)CO ₂ H	200
90	глутатион	Glutathione	70-18-8	C10H17N3O6S	20
91	Глицерил моностеарат	Glyceryl monostearate	31566-31-1	C21H42O4	10,000
92	Глицине	Glycine	56-40-6	C2H5NO2	4
93	Усан үзмийн үрийн ханд	Grapefruit Seed Extract	90045-43-5	Not available.	10
94	Усан үзмийн үрийн ханд	Grapeseed extract	84929-27-1	C30H12O6	36
95	гуар-гидроксипропилтримони хлорид	Guar Hydroxypropyltrimonium Chloride	9000-30-0, 65497-29-2	C6H16NO2	10
96	Гугулипид	Gugulipid			60
97	Гимнема Силвестра	Gymnema Sylvestra	90045-47-9	Not available.	20
98		Gym powder			200
99	Гели /gas/	Helium /хий/	7440-59-7	He2	1,000
100	Гептан	Heptane	142-82-5	C7H16	200
101	Гексан	Hexane	110-54-3	C6H14	60
102	Поли этилин HDPE	High-density polyethylene, HDPE	9002-88-4	[CH2CH2]n	200
103	Гаулроныхүчил	Hyaluronic Acid	9004-61-9	C14H21NO11)n	200
104	гиалораны хүчил	Hyaluronic acid powder	9004-619	(C14H21NO11)n	20

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
105	Давсны хүчил	Hydrogen chloride (37%, extra pure)	7647-01-0	HCl	100,000
106	устөрөгчийн хэт исэл	Hydrogen peroxide	CAS 7722-84-1	H ₂ O ₂	10,000
107	Гидролизжүүлсэн коллаген	Hydrolyzed Collagen	92113-31-0 / 73049-73-7	C ₁₈ H ₃₅ O	1,600
108	Гидролизийн поли акрилонитрил натри	Hydrolyzed Polyacrylonitrile sodium salt	61788-39-4	variable	100,000
109	Гидроксиэтилцеллюлоз	Hydroxyethylcellulose	9004-62-0	CH ₂ CH ₂ OH	100
110	Гидроксипропилметицеллюлоз	Hydroxypropylmethyl cellulose	9004-65-3	Not available.	1,000
111	Ибупрофен	Ibuprofen	15687-27-1	C ₁₃ H ₁₈ O ₂	90
112	1-инденеон	Indeneone	83-33-0	C ₉ H ₈ O	6
113	Иод	iodine	5010-4425	I ₂	200
114	Иод -0.1н/фикс/	Iodine	7553-56-02	J ₂	4
115	Иод	Iodine	7553-56-2	I ₂	200
116		Jelly soap base		Not available.	-
117	Нунтаг кератин	Keratin powder	69430-36-0	C ₂ H ₂ BrClO ₂	80
118		Kappa carrageenan	11114-20-8		2,000
119	Л-аргинин	L-Arginine	74-79-3	C ₆ H ₁₄ N ₄ O ₂	60
120	Лаурамин исэл	Lauramine oxide	61788-90-7	C ₁₂ H ₂₇ NO	2,000
121	Л-карнитин	L-carnitine	541-15-1	C ₇ H ₁₅ NO ₃	20
122	Левулиник-ийн хүчил	Levulinic acid	123-76-2	C ₅ H ₈ O ₃	2
123	Алкил бензол сульфоны хүчил LAS	Linear alkyl benzene sulphonic acid/ LAS	6484-52-2	CH ₃ (CH ₂) ₁₁ C ₆ H ₄ SO ₃ H	2,000
124	серамид	Liquid ceramide	100403-19-8	C ₃₆ H ₇₁ NO ₄	60
125		Locust bean gum	9000-40-2		200
126	Поли этилин LDPE	Low-density polyethylene, LDPE	9002-88-4	[CH ₂ CH ₂] _n	200
127	Л-Селенметионин	L-selenmethionine	3211-76-5	C ₅ H ₁₁ NO ₂ Se	20
128	Ликопен	Lycopene	502-65-8	C ₄₀ H ₅₆	20
129	Магни ацетат	Magnesium acetate	142-72-3	Mg(Ac) ₂	200
130	Хүхэр хүчлийн Магни (Эпсоны давс)	Magnesium sulfate(Epson salt)	7487-88-9	MgSO ₄ H ₂ O	20,000
131	Магнийн таурате	Magnesium taurate	107-35-7	C ₄ H ₁₂ N ₂ O ₆ S ₂ Mg*2H ₂ O	400
132	Манганийн глюконат	Manganese gluconate	6485-39-8	C ₁₂ H ₂₂ MnO ₁₄	200
133	сульфат марганец	manganese sulfate	7785-87-7	MnSO ₄ 5H ₂ O	14,000
134	Метил ди гидро жасмонат	Methyl dihydrojasmonate	24851-98-7	C ₁₃ H ₂₂ O ₃	20
135	Метил-п-гидроксибензоат	Methyl-p-hydroxybenzoate	99-76-3	C ₈ H ₈ O ₃	20
136	Микро талст целлюлоз	Microcrystalline cellulose	9004-34-6	(C ₆ H ₁₀ O ₅) _n	10,000
137	Мио Инозитол	Myo-inositol	87-89-8	C ₆ H ₁₂ O ₆	100
138		Mango kosher butter		Not available.	80
139		Melt&Pour african black soap base		Not available.	170
140		Melt&Pour crystal aloe base		Not available.	170

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
141		Melt&Pour crystal argan base		Not available.	180
142		Melt&Pour crystal triple butter base		Not available.	180
143		Melt&Pour shea base		Not available.	180
144		Melt&Pour SLES SLS-Free clear base		Not available.	180
145		Melt&Pour crystal oatmeal shea base		Not available.	180
146		Melt&Pour ST-Clear base		Not available.	180
147		Melt&Pour WST-White base		Not available.	180
148	N-Ацетил-N-карнитин	N-Acetyl-L-Carnitine	14992-62-2	C ₉ H ₁₇ NO ₄	20
149	Далайн замаг ба нарсны ханд 10%	Natural Sap Compounded Water 10%	Pine extract 94266-48-5 Seaweed extract 68917-51-1 water 7732-18-5	Ханд экстракт	100,000
150	Нийм-ийн тос	Neem Oil	8002-65-1	Not available.	10
151	Витамин В3	niacin (vit B3)	59-67-6	C ₆ NH ₅ O ₂	10
152	Никотинамид	Nicotinamide	98-92-0	C ₆ H ₆ N ₂ O	10
153	никотины хүчил витамин В3	Nicotinic acid vitamin B3	59-67-6	C ₆ H ₅ NO ₂	30
154	Никел нитрат	Nikel nitrate	13138-45-9	Ni(NO ₃) ₂	10
155	Оливийн тос PEG-7 эфир	Olive oil PEG-7 esters	103819-46-1		140
156	Цетиарил оливат, сорбитан оливат	Olivem 1000	85116-80-9 / 92202-01-2	C ₂₄ H ₄₄ O ₆	100
157		Olive squalana oil		Not available.	100
158			Olive butter	Not available.	100
159	Оливийн тос ПЭГ-7 эфир	Olivem 300	226708-41-4		160
160	Орто-фтальальдегид	ortho-phtaldehyde	643-79-8	C ₆ H ₈ O ₂	60
161	Пантенол витамин В5	Panthenol vitamin B5	116485-10-2, 8113-0 R	C ₉ H ₁₉ NO ₄	6
162	Витамин В5	Pantothenic acid (vit B5)	599-54-2	C ₉ H ₁₇ NO ₅	20
163	Метил глюкозын диолеат	PEG-120	86893-19-8		1,200
164	Пентан	Pentane	109-66-0	C ₅ H ₁₂	20
165	Пепперминт тос	Peppermint oil	8006-90-4	Not available.	20
166	Пера сейф	Pera Safe		variable	10
167	Петролейний эфир	petroleum ether	8030-30-6	CH ₃ CH ₂ OCH ₂ CH ₃	60
168	Феноксэтанол	Phenoxyethanol	122-99-6	C ₈ H ₁₀ O ₂	100
169	Фито агар	Phytogar			1,000
170	Пироксикам	Piroxicam	36322-90-4	C ₁₅ H ₁₃ N ₃ O ₄ S	20
171	Поли акрил амид А-330РН	polyacrylamide А-330РН	2594446	[-CH ₂ -CH(CONH ₂)-] _n	100,000

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
172	Поли акрил амид С-980ПЛ	polyacrylamide C-980PL	2594446	$[-CH_2-CH(CONH_2)-]_n$	100,000
173	Поли акрил амид ФЛ-45С	polyacrylamide FL-45C	2594446	$[-CH_2-CH(CONH_2)-]_n$	2,000
174	полиакрилонитрил	polyacrylonitril	25014-41-9.	$(C_3H_3N)_n$	120,000
175	Полидадмак	polydadmac	26062-79-3	$(C_8H_{16}NCl)_n$	100,000
176	Полисорбат 60	Polysorbate 60	9005-67-8	$C_{64}H_{126}O_{26}$	200
177	Иодат кали	Potassium Iodate	6598-4425	KIO_3	200
178	Бикарбонат кали	Potassium bicarbonate	298-14-6	$KHCO_3$	6,000
179	кальцжуулсан кали	potassium calcined		K_2CO_3	100,000
180	карбонат кали	potassium carbonate	0584-08-07	K_2CO_3	100,000
181	Калийн хлорид	Potassium Chloride	7447-40-7	KCl	2,000
182	Калийн гидроксид	potassium hydroxide	1310-58-3	KOH	2
183	Иодат кали	Potassium iodate	6598-4425	KIO_3	200
184	Калий иодат-0.1н /фиксанал/	Potassium iodate	5/6/7758	KJO_3	2
185	Азот хүчлийн кали	Potassium nitrate	7757-79-1	KNO_3	1,000
186	Калийн перманганат-0.1н/фиксанал/	Potassium permanganate	7722-64-7	$KMnO_4$	6
187	калийн сорбат	Potassium Sorbate	24634-61-5	$C_6H_7O_2K$	140
188	Пролине	proline	609-36-9	$C_5H_9NO_2$	4
189	Пропионы хүчил	Propionic acid	79-09-4	CH_3CH_2COOH	100
190	Пропил-п-гидроксибензоат	Propyl-p-hydroxybenzoate	94-13-3	$C_{10}H_{12}O_3$	20
191	Витамин В6 (пероксидине)	Pyridoxine (vit B6)	65-23-6	$C_8H_{11}NO_3$	20
192	Улаан дрожит будааны ханд	Red yeast rice extract	75330-75-5	Not available.	20
193	Витамин В2	Riboflavin (vit B2)	83-88-5		20
194	Сарнайн ханд	Rosemary Extract	Not available.	Not available.	20
195	С-Аденозил-Л-Метионин	S-Adenosyl-L-Methionine	29908-03-0 Yes	$C_{15}H_{22}N_6O_5S$	3
196	Салицилийн хүчил	Salicylic acid	69-72-7	$C_6H_4(OH)COOH$	100
197	Салицилийн хүчил	Salicylic acid	69-72-7	$C_7H_6O_3$	100
198	Скопия нунтаг	Scopia powder			60
199	Селен цистеин	Selenosysteine			2
200	Шиа масло	Shea Butter			50
201	Амино хүчил	Silk amino acid	96690-41-4	$C_3H_7NO_2$, $C_2H_5NO_2$, $C_3H_7NO_3$, $C_5H_{11}NO_2$, $C_4H_9NO_3$	8
202	Азот хүчлийн мөнгө	Silver Nitrate	7761-88-8	$AgNO_3$	200
203	Сульфодиазины мөнгө	Silver Sulfadiazine	22199-08-2	$C_{10}H_9AgN_4O_2S$	20
204	кальцжуулсан сод	soda ash .calcined soda	497-19-8	Na_2CO_3	100,000
205	кальцжуулсан сод	soda calcined		Na_2CO_3	120,000
206	Натрийн бензоат	Sodium benzoate	532-32-1	$C_7H_5O_2Na$	100
207	Боргидрид натри	Sodium Borohydrate	16940-66-2	$NaBH_4$	20

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
208	карбонат натри	sodium carbonate	497-19-8;	Na ₂ CO ₃	120,000
209	Натрийн карбоксиметилцеллюлоза	Sodium carboxymethyl cellulose	9004-32-4	Not available.	100,000
210	Натрийн хлорид	Sodium Chloride	7647-14-5	NaCl	140,000
211	Нимбэгний хүчлийн натри	Sodium citric acid	144-33-2	C ₆ H ₆ Na ₂ O ₇ *H ₂ O	600
212	натри карбокси метилцеллюлоза	sodium CMC	2593534		1000,000
213	Натрийн гиалуронат	Sodium Hyaluronate	9067-32-7	C ₂₈ H ₄₄ N ₂ O ₂₃ ·Na	10
214	Натрийн гидроксид	sodium hydroxide	1310-73-2	NaOH	4
215	Натрийн гидроксид-0.1н	sodium hydroxide	1310-73-2	NaOH	5
216	Гипохлорит натри	Sodium hypochlorite	7681-52-9	NaClO	600
217	Лигнин сульфат натри	Sodium lignin sulfonate	9009-75-0	variable	100,000
218	Лигнин сульфат натри	Sodium lignin sulfonate	9009-75-0	variable	100,000
219	Азот хүчлийн натри	Sodium nitrate	7631-99-4	NaNO ₃ .	10,000
220	Нитрит натри	Sodium nitrite	7632-00-0	NaNO ₂	1,000
221	натри полиакриламид	sodium PAA	2594415	(C ₃ H ₃ NaO ₂) _n	100
222	Селенат натри	Sodium selenate	13410-01-0	Na ₂ O ₄ Se	100
223	Натри тиосульфат - 0.1н /фиксанал/	Sodium thiosulfate	7772-98-7	Na ₂ S ₂ O ₃	10
224	Натри тиосульфат - 95%	Sodium thiosulfate	7772-98-7	Na ₂ S ₂ O ₃	20
225	Сорбины хүчил	Sorbic acid	110-44-1	C ₆ H ₈ O ₂	100
226	Сорбитан оливат ба цетеарил оливат	Sorbitan olivate and cetearyl olivate	223706-40-9	C ₂₄ H ₄₄ O ₆	100
227	Сорбиталь С	Sorbitol C	50-70-4	C ₆ H ₁₄ O ₆	10
228	шар буурцгийн лецитин	Soy lecithin	8002-43-5	C ₃₅ H ₆₆ N ₇ O ₇ P	100
229	Стеарат натри	Stearat natri			200
230	Стронцийн карбонате	stroncium carbonate	1633-05-2	SrCO ₃	2
231	Хувын хүчил	Succinic acid	110-15-6	HOOC-CH ₂ -CH ₂ -COOH	700
232	Сульфодиазин	Sulfadiazine	68-35-9	C ₁₀ H ₁₀ N ₄ O ₂ S	30
233	серная кислота	sulfuric acid	7664-93-9	H ₂ SO ₄	100,000
234	Сахроз	Surcose	57-50-1	C ₁₂ H ₂₂ O ₁₁	20
235		Sheanut unrefined butter			20
236	Таурин	Taurine	107-35-7	C ₂ H ₇ N ₃ S	40
237	Тетра этилт орто силикат	Tetraethyl ortho silicate	78-10-4	SiC ₈ H ₂₀ O ₄	2,000
238	Витамин В1	Thiamine (vit B1)	59-43-8	C ₁₂ H ₁₇ N ₄ O ₅ S	10
239		Thermophilic starter			120
240	Токоферил ацетат	Tocopheryl Acetate	7695-91-2	C ₃₁ H ₅₂ O ₃	10
241	тритон х-100	triton X-100	9002-93-1	C ₁₄ H ₂₂ O(C ₂ H ₄ O) _n (n=9-10)	4
242	Твин 80	Tween 80	9005-65-6	C ₆₄ H ₁₂₄ O ₂₆	200
243	Убикуйнол	Ubiquinole	992-78-9	C ₅₉ H ₉₂ O ₄	20

УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Cas№	Томьёо	1 Жилийн хэрэгцээ/кг
244	Ванадил сульфат	Vanadium sulfate	27774-13-6	VOSO4	10
245	Витамин А	vitamin A	68-26-8	C6NH5O2	10
246	Витамин В6	Vitamin B6	8059-24-3	C10H16N2O3S	20
247	Витамин В7	vitamin B7(biotin)	58-85-5	C10H16N2O3S	10
248	Витамин В9	Vitamin B9(Ubihinone)	59-30-3	C19H19N7O6	10
249	Витамин К2	Vitamin K2, menaquinone-7 (MK7)	863-61-6	C31H40O2	20
250	витамин рр ниацин	vitamin PP,niacin	CAS: 59-67-6	C6H5NO2	20
251	Ксантан бохь	Xanthan gum	11138-66-2	C35H49O29	200
252	Киситол	Xylitol	87-99-0	C5H12O5	200
253	Хлорат цайр	Zinc chlorate	10361-95-2	Cl2O6Zn	10
254	Нимбэгний хүчлийн цайр	Zinc Citrate	546-46-3	C12H14O16Zn3	200
255	Нитрат цайр	Zinc nitrate	7779-88-6	Zn(NO3)2	100
256	Цайрын исэл	Zinc oxide		ZnO	30
257	Фосфат цайр	Zinc phosphate	7779-90-0	Zn3(PO4)2	100
258	сульфат цайр	Zinc sulfate	7733-02-0	ZnSO4 7H2O	12,000
259	Хүхэр хүчлийн цайр	Zinc Sulfate	7446-20-0	ZnSO4	2,000
260	Пепперминтын тос	Peppermint oil	2238939	C62H108O8	10

1.8. Төслийн дэд бүтэц

“Монхимо” ХХК-ний төслийн талбай нь Улаанбаатар хотын Багануур дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт оршиж байгаа бөгөөд дэд бүтэц, зам, гэрэл цахилгаан, интернэт, цахилгаан холбоо болон үүрэн телефон холбоогоор бүрэн холбогдсон дэд бүтэц сайн хөгжсөн газарт байрладаг.

Унд ахуйн хэрэглээний цэвэр ус

Цэвэр ус –Уг төсөл нь төвлөрсөн системд холбогдсон байна. Төсөлд нийт 32 хүн ажиллана. Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ахуйн хэрэгцээнд 200* л байна гэж үзвэл 32 хүн х 200 л = 6400 л/хоног буюу 6.4 м³/хоног, сард 192м³ жилд 1888 м³ ус ашиглахаар байна. (*- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт–“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдсон орон сууц – 200 л/хоног/хүн)

Хүснэгт 3. Төслийн ажилчдын унд ахуйн усны тооцоо

Усны хэрэглээний төрөл	Төслийн хугацаа, хон/жил	Норм	Хүний тоо	Ус хэрэглээ	
				м ³ /хон	м ³ /жил
Унд-Ахуйн	295	200 л/хон/хүн	32	6.4	1888

Ногоон байгууламжийн усалгаа: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам талбайн усны норм” Цэцэрлэг зүлэг, ногоо услах 4.0 м³

Хүснэгт 4. Ногоон байгууламжийн усалт

Усны хэрэглээний төрөл	Усалгаа жил/хоног	Норм	Талбайн хэмжээ, м2	Ус хэрэглээ	
				м3/хон	м3/жил
Ногоон байгууламжийн усалгаа	19	4.0л	810	3.2	61.6

**УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Бүтээгдэхүүний усны норм: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 8 дугаар хавсралт “Био бэлдмэлийн үйлдвэрийн усны норм” Уургийн бүтээгдэхүүн 1тн 10 м³

Хүснэгт 5. Эмийн үйлдвэрийн усны хэрэглээ

Усны хэрэглээний төрөл	Төслийн хугацаа, хон/жил	Норм	Хүчин чадал	Ус хэрэглээ	
				м ³ /хон	м ³ /жил
Уургийн бүтээгдэхүүн	295	10 м ³	1.5тн	15	4425

2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖСайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, дүгнэх ажлын хэсгийг харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар энэ журмын 4.1-д заасан хугацаанд байгуулна. Ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дарга ахлах бөгөөд байгаль орчны газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн дарга байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газраас батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, нөхөн сэргээх, бохирдсон болон доройтсон орчныг цэвэрлэх, сэргээх үүргээ биелүүлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлж болно.

Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

Бусад нөхцөл. Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх барьцаа хөрөнгийг төвлөрүүлэх, буцаан олгохтой холбогдсон харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.15-д заасан журмаар зохицуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.





**УЛААНБААТАР ХОТЫН БАГАНУУР ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭМИЙН
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


Хүснэгт 6. БОМТөлөвлөгөөний зардлын дүн

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7 470,0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	1104,0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2863,40
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3 210,0
	Нийт дүн	16 297,4
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	256,0
Нийт		16 553,4

2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	1. Агаар орчинд		
	Гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээний биелэлт	Гүйцэтгэлийн баримт хавсралт
1		Агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавьсан	<p>Үйлдвэр болон агуулахын доторх агааржуулалтын систем</p>  
2		Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэсэн	
3	Агуулах болон үйлдвэрийн хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын ууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Ажилчдын эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажлын байрандаа зориулалтын механик сордог агааржуулагч тавих	

2.Хөрсөн орчинд			
1	<p>Химийн бодисын санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрснийг бохирдуулна.</p>	<p>Аюултай хаягдлыг тусгай зориулалтын цэг саванд төвлөрүүлж байгаа.</p> <p>Мөн химийн бодис санамсаргүй асгарах,болон алдагдах үед саармагжуулах болон хаягдлын төвлөрүүлэх тусгай хогны сав байрлуулсан</p>	 
2	<p>Химийн бодис тээвэрлэх ачиж буулгах Хөрс элэгдэж эвдрэл орно Мөн хүн, машины хөдөлгөөний улмаас агуулахын орчмын хөрс элэгдэлд орно. Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн болсон зүйлийг ачиж тээвэрлэх үед</p>	<p>-Химийн бодис буулгах,ачих үеийн хөрсний гэмтэл бохирдлоос сэргийлж агуулахын орчныг бүтэн хучилтай зам тавьсан.</p> <p>-байгууламжийн ойр орчныг тогтмол арчилж тордож байгаа.</p>	 <p>Химийн бодис ачих,буулгах агуулахын хэсэг</p>  <p>Үйлдвэрийн гадна талбай</p>

3.Газрын доорх усны асуудал			
3	Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Уг төсөл нь төвийн төвлөрсөн системд холбогдсон байна	Эмийн үйлдвэрийн төсөлд хоногт 24.6м3, жилд 6374.6м3 ус ашиглахаар байна. Төвлөрсөн системд холбогдсон тоолуурын заалтын дагуу төлбөрөө төлдөг.
	Үйлдвэрт ашиглагдаж байгаа тоног, төхөөрөмж,бусад багаж хэрэгслийг цэвэрлэсэн хаягдал ус нь хөрс болон агаарт сөрөг нөлөөлөх магадлалтай.	Үйлдвэрт ашигласан хаягдал усыг тусгай бохир хадгалах саванд хадгалж саармагжуулалд хийсний дараа төвийн төвлөрсөн байгууламжид нийлүүлдэг бөгөөд тухай бүрд бохир хаягдалд шинжилгээ хийдэг.	Хаягдал усны шинжилгээг нэмэлт баримтад хавсаргав.
4.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл			
1	Гал түймрийн аюулаас урьдчилан дохиоллын суурилуулах сэргийлэх систем	Эмийн үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсэн бөгөөд гал түймэр болон гэнэтийн ослоос сэргийлсэн дохиолол,хяналтын систем суурилуулсан	<p>Үйлдвэрийн дотор болон гадна талын хяналтын камер,галын дохиолол</p> 

<p>2</p>	<p>Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах</p>	<p>-Үйлдвэр болон агуулахын талбайд галын аюулын санамж бүхий тэмдэг тэмдэглэгээ,самбар байршуулсан -Мөн яаралтай үед хэрэглэх галын хэрэгслийг галын булан байршуулсан -2025.5.20 нд “Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа”сэдэвт ХАБЭА-ийн сургалтад ажилчдыг хамруулж гэрчилгээ олгосон.</p>	<div data-bbox="1182 193 2128 608"> </div> <p>галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж анхааруулах самбар</p> <div data-bbox="1227 691 1608 1219"> <p>Гуугай зөвшөөрөл: 171003261 ГЭРЧИЛГЭЭ Дугаар № 25/С-274 Хүндэт <i>В. Жавранжамъян</i> танд "Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа" сэдэвт ХАБЭА-н сургалтанд хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов. "МКЛ" ХХК-ийн дэргэдэх сургалтын төвийн захирал <i>Д.Хоролсүрэн</i> Д.ХОРОЛСҮРЭН Олгосон: 2025.05.20</p> </div> <div data-bbox="1680 691 2078 1219"> <p>Гуугай зөвшөөрөл: 171003261 ГЭРЧИЛГЭЭ Дугаар № 25/С-275 Хүндэт <i>И. Ватлуца</i> танд "Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа" сэдэвт ХАБЭА-н сургалтанд хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов. "МКЛ" ХХК-ийн дэргэдэх сургалтын төвийн захирал <i>Д.Хоролсүрэн</i> Д.ХОРОЛСҮРЭН Олгосон: 2025.05.20</p> </div>
----------	--	---	--

	<p>Химийн бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах</p>	<p>“Чагнуур” эмч, мэргэжилтнүүдийн нийгэмлэг ТББ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн давтан сургалтыг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байран дээрхи хэрэгцээтэй сургалтад мэргэжилтнүүдийг хамруулсан.</p>		
<p>5.Осол, эрдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</p>				
<p>3</p>	<p>Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохиож байх</p>	<p>-Химийн бодистой ажиллах заавар зөвлөмжийг тогтмол өгдөг ба яаралтай үед хэрэглэх эмийн санг байршуулсан -Химийн бодисыг санамсар ,болгоомжгүйгээс асгах үед яаралтай ашиглах асгаралтын багцыг агуулахад байршуулж ажилсан.</p>		

4	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн хангах	-хөдөлмөр хамгааллын хэрэгслийг бүрэн хангаж ажилдаг.	
---	--	---	---

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /ургамлын нөмрөг хамгаалах/

№	Нөхөн сэргээлтийн авах арга хэмжээ	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний хийгдсэн арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
1	Төслийн орчинд, ногоон байгууламж бий болгох	<p>-Төслийн талбайн боломжит хэсэгт ногоон байгууламж бий болгосон бөгөөд байнгын арчилгаа,усалгаа хийгддэг</p> <p>-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутаг үйлдвэрийн дэргэд зам дагуу мод тарьсан</p> <p>-2024 онд үйлдвэрийн талбайн баруун талд байрлах хүлэмжинд үрслүүлсэн суулгацыг голын дагуу шилжүүлэн суулгах ажил хийгдсэн.</p>	
2	Ногоон байгууламжид арчилгаа тордлогоо хийх	<p>Үрээр суулгац тарьж бойжуулж байгаа</p> <p>Бөгөөд тус ажилаа мөн үргэлжүүлэн явуулж байгаа</p>	 <p>үрээр суулгасан суулгацууд</p> <p>Мод үржүүлгийн хүлэмж</p>

7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Монхимо” ХХК нь “ Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах. энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, барилга барих, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцна.” гэж заасны дагуу энгийн хог хаягдлаас гадна аюултай хог хаягдлаа дараах үе шатуудаар зайлуулдаг.

- Дахин боловсруулах боломжтой хогийг төмөр, хуванцар, мод, цаас, шил гэх мэтээр төрөлжүүлэн ангилах, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх,
- Байгальд халгүй аргаар устгах,
- Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал устгах, тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй газартай гэрээ байгуулан зайлуулах, тэмдэглэл, бүртгэл хөтлөх.

Хатуу хог хаягдал: Хатуу хог хаягдлын ихэнх нь ахуйн гаралтай хаягдал байна. Хог хаягдлыг Багануур дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу хүлээлгэн өгдөг.

Аюултай хог хаягдал: Тус төслийн хүрээнд агуулахын хадгалалтын нөхцөлөөс гарч болзошгүй аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-тай хийсэн гэрээний дагуу хүлээлгэн өгч устгуулдаг. Аюултай хог хаягдлыг түр хадгалахдаа аюулгүй байдлыг бүрэн хангаж, галын хор саармагжуулах бодис зэргийг байршуулан ажиллаж байна.

БАТЛАВ:

“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Б.ЭНХБАДРАЛ/



БАТЛАВ:

“МОНХИМО” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

/М.АРИУНАА/



ХИМИЙН ХОРТОН БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ ХБ-25/108

2025 оны 05-р сарын 01-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас “Элемент” ХХК РД: /2100061/ /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун, нөгөө талаас /цаашид “Захиалагч” гэх/-ыг “МОНХИМО” ХХК РД: /2559994/ түүнийг төлөөлж Менежер албан тушаалтай А.Мөнхзул нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
 - 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг өөрийн хими технологийн үйлдвэрлүү ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.
 - 1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.
 - 1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/
 - 1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг
 - 1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
 - 1.2.4 “Элемент” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1. Захиалагч дараах эрхтэй:
 - 2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
 - 2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
 - 2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.
- 2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
 - 2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
 - 2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
 - 2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,
 - 2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,
 - 2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
 - 2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

- 2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,
- 2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог хаягдал ачилт хийж өгөх.
- 2.2.9. Аюултай хог хаягдлаа гэрээний хүчинтэй хугацаанд багтаан 4.3-т заасны дагуу хүлээлгэн өгч устгуулах.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:
- 3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
- 3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,
- 3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, “аюултай” гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаардах, хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,
- 3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй
- 3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:
- 3.2.1. Хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,
- 3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,
- 3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,
- 3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,
- 3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах
- 3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,
- 3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.
- 3.2.8. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.
- 4.2. Энэхүү гэрээ 2025 оны 05-р сарын 01-ны өдрөөс 2026 оны 05-р сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэнэ.
- 4.3. Захиалагч гэрээний баталгаа болгож урьдчилгаа төлбөр болох **500,000.0 /Таван зуун мянга/** төгрөгийг Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан дансанд байршуулснаар гэрээ батлагдана. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.
- 4.4. 4.3-т заасан урьдчилгаа төлбөр нь зөвхөн энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд үйлчилгээний төлбөрөөс хасагдаж тооцогдоно.
- 4.5. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.
- 4.6. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн “Элемент” ХХК-ийн **1715164140 /Голомт банк/** тоот дансанд бэлэн бусаар төлнө.

- 4.7. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой объектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,
- 4.8. Төлбөр тооцоог зөвхөн Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан байгууллагын дансанд төлөх бөгөөд тус данснаас бусад хувь хүний дансандшилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.
- 4.9. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэм буруутай тал нөгөө талдаа учирсан хохирлыг төлнө.
- 5.2 Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг Гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд ХАБЭА-н зааварчилгааны дагуу ажиллах үүрэгтэй.
- 5.3 Захиалагч талын байгууллагын бүсэд нэвтэрсэн тохиолдолд захиалагч талаас тавьсан ХАБЭА-н шаардлагыг гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд Элемент ХХК-ийн тээврийн хэрэгслийг давуу эрхийн дагуу хөдөлгөөнд оролцуулна.
- 5.4 Захиалагч тал гүйцэтгэгч талын ажлаа явуулах боломжоор байгууллагын хүрээнд хангаж өгөх үүрэг хүлээнэ.
- 5.5 Талууд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар болон бусад холбогдох зүйлд заасан шаардлагыг ханган хамтран ажиллах үүрэгтэй.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.
- 6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.
- 7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

- 8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 10.1. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 10.1.1. Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,
 - 10.1.2. Талууд харилцан тохиролцсож гэрээг цуцалснаар,
 - 10.2. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна. Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана. Үүнд:
 - 10.2.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй,
 - 10.2.2. Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан,
 - 10.2.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

АРАВ. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА, БУСАД

- 11.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.
- 11.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 11.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.
- 11.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.
